



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2024 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/203

Улаанбаатар хот

“Монголын хөрөнгийн бирж” ХК-д
гишүүнчлэлтэй үнэт цаасны компаниудад
газар дээрх шалгалт хийх тухай

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1.6, Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн “Гишүүнчлэлийн журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.1, “Хяналт шалгалтын журам”-ын 6 дугаар зүйлийн 6.1, 9 дүгээр зүйлийн 9.3.2, 9.4, Дүрмийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.9.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Гишүүн үнэт цаасны компаниудад хийх газар дээрх шалгалтыг 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдрөөс 06 дугаар сарын 30-ны өдрийг дуустал хугацаанд зохион байгуулсугай.
2. Гишүүн үнэт цаасны компаниудад хийх газар дээрх шалгалтын удирдамжийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
3. Шалгалтын багийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:
Ахлагч: Ё.Билгүүнтуяа (Хяналт шинжилгээний албаны ахлах мэргэжилтэн)
Гишүүд: Б.Наранцэцэг (Хяналт шинжилгээний албаны мэргэжилтэн)
Ц.Ганчимэг (Хяналт шинжилгээний албаны мэргэжилтэн)
Д.Өлзийбат (Хяналт шинжилгээний албаны мэргэжилтэн)
Г.Тайвантуяа (Мэдээлэл технологийн албаны ахлах мэргэжилтэн)
Н.Отчигин (Зах зээл хөгжлийн албаны мэргэжилтэн)
4. Хяналт шалгалт хийсэн ажлын үр дүнгийн тайланг 2024 оны 07 дугаар сарын 19-ний дотор танилцуулахыг Хяналт шинжилгээний алба (Ё.Билгүүнтуяа)-нд үүрэг болгосугай.
5. Хяналт шалгалтыг хэрэгжүүлэхэд шаардагдах унааны зардлыг холбогдох төсвийн дагуу олгохыг Захиргаа санхүүгийн газар (Х.Эрдэнэбүрэн)-т зөвшөөрсүгэй.

1524030470